


ХЭРЛЭН СУМЫН МАН-ЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

НЭГ: ЭРҮҮЛ ИРГЭН

- 1.1. Иргэн бүрийг эрүүл мэндийн багц оношилгоонд жил бүр хамруулна.
- 1.2. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд сэргээн засах, чийрэгжүүлэх, физик эмчилгээний тоног төхөөрөмж, ЭХО, Өндөгний цусны дэлгэрэнгүй шинжилгээний аппараттай болгох.
- 1.3. “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн хүрээнд сумандаа “Эрүүл иргэн” хөтөлбөрийг 100 хувь хэрэгжүүлнэ.
- 1.4. Хеликобактеритай тэмцэх, хянах үндэсний хөтөлбөрийн хүрээнд ходоодны архаг үрэвсэл, шарх, хорт хавдрын эрт илрүүлэг оношлогоо эмчилгээг эрчимжүүлнэ.
- 1.5. Эрүүл шүд – Эрүүл хүүхэд аяны хүрээнд хөтөлбөрийн хүрээнд, хүүхдийн хоолойн архаг ангины өвчнийг эрт илрүүлэн эмчлэх, ирээдүйд учрах эрүүл мэндийн эрсдэлээс бага насанд нь сэргийлэх ажлыг зохион байгуулна.
- 1.6. Амьжиргааны баталгаажих төвшин доогуур орлоготой иргэдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах “Цахим карт” олгоно.
- 1.7. Иргэдэд эрүүл мэндийн бүх талын боловсролыг ЕБС-д суралцаж байх үеэс олгож, эрүүл мэндийн “анхны тусламж” үзүүлэх чадавхыг хүн бүрд эзэмшүүлнэ.
- 1.8. “Идэвхтэй эрүүл амьдрал” хөтөлбөрийг хэрэгжүүлж, дасгал хөдөлгөөн зөв хооллолт, стресс бухимдлаас ангид байх эрүүл амьдралын дадал хэвшлийг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хэрэгжүүлнэ.
- 1.9. Унадаг дугуй унах, гүйх, дасгал хөдөлгөөн хийх, бие бялдраа хөгжүүлэх, эрүүл байхад чиглэсэн хөдөлгөөн, санаачлалыг бодлогоор дэмжинэ.
- 1.10 Хэрлэн сумын VI дугаар багт өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээг шийдүүлж ахмадын эмчтэй болгоно.

ХОЁР: НИЙГМИЙН ХАЛАМЖ, ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР

- 2.1 Өрхийн амьжиргааны төвшин тогтоох аргачлалд тулгуурлан нийгмийн халамжийн үйлчилгээ, хүнсний талон зэргийг зорилтот бүлэгт чиглүүлнэ.
- 2.2 Орлого багатай өрхийн нийгмийн хамгаалал, амьжиргааг дээшлүүлэх зорилгоор олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг нэвтрүүлнэ.



- 2.3. Нөхөрлөл хоршоо байгуулах, өрхийн аж ахуй эрхлэлтийг бүх талаар дэмжиж ажиллана.
- 2.4. 40-өөс дээш насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- 2.5. Хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагааг дэмжиж ажиллана.
- 2.6. Гэр бүлийн хүчирхийлэл болон хүүхэдтэй холбоотой асуудлаар зөвлөгөө өгөх үйлчилгээг баг бүрд бий болгоно.
- 2.7. Залуу гэр бүлийн эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа, сэтгэл зүй, өрхийн хөгжлийг дэмжсэн олон тал ажлыг зохион байгуулна.
- 2.8. Залуучуудын зөвлөл, сайн дурын санаачлагыг дэмжинэ.
- 2.9. Тусгай хэрэгцээт /хөгжлийн бэрхшээл/-тэй иргэдэд хэрэгцээг үйлчилгээгээ авах нөхцөлийг төрийн болон төрийн бус байгууллагуудад бүрдүүлнэ.
- 2.10 Ахмадын зөвлөх үйлчилгээ хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.
- 2.11 Байнгын асаргаа сувилгаа шаардлагатай ахмадуудад зориулсан төрөлжсөн асрамж, сувиллын үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.
- 2.12 “Ахмадаа хүндэтгэе” арга хэмжээг жил бүрийн ахмадын баяраар зохион байгуулж хүндэтгэл үзүүлнэ.

ГУРАВ: ХӨДӨӨ АЖ АХУЙ

- 3.1 ХАА-н салбарт малчид, тариаланчдын залгамж халааг бэлтгэх “Илгээлтийн эзэн-3 аяныг сум андаа хэрэгжүүлнэ.
- 3.2 Мал амьтны гаралтай арьс шир үс ноос боловсруулж оёмол сүлжмэл ,арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх иргэдийг дэмжиж түүхий эдээ эдийн засгийн эргэлтэд оруулах бодлогыг хэрэгжүүлнэ.
- 3.3 Малын толгой шийр гэдэс дотор дайвар бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэлийг дэмжиж тухайн чиглэлийн төсөл хөтөлбөрийг дэмжиж ажиллана.
- 3.4 Монгол мал-2 хөтөлбөрийн хүрээнд малыг эрүүлжүүлэх, үүлдэр угсааг сайжруулах бодлогыг хэрэгжүүлж малын тоог чанарт шилжүүлж ашиг шимийг нэмэгдүүлж, малын генийн санг хамгаална.
- 3.5 Сүү махны чиглэлийн эрчимжсэн аж ахуйнуудыг дэмжиж, Сүүний аж ахуй эрхлэгч айл өрх ААН-эгжүүдийг нэгдсэн зохион байгуулалтад оруулж суурьшлын бүсийг тогтоон тэдгээр иргэдийг тоног төхөөрөмж усан хангамж төсөл хөтөлбөрт хамруулж бодлого чиглэлээр дэмжин хамтран ажиллана.



3.6 Малжуулах төслийг үргэлжлүүлж залуу малчдын өрхийн орлогыг нэмэгдүүлэх шинээр ХАА-н салбарт ажиллах залуусыг бодлогоор дэмжин илгээлтийн эзэн-3 аяныг эхлүүлж хэрэгжүүлнэ.

3.7 Хэрлэн сумын 3,5 дугаар багуудад мал угаах ванн барьж ашиглалтад оруулна.

3.8 Мал эмнэлгийн лабораторийн төрөлжсөн нэг цэгийн үйлчилгээг бий болгож мал амьтны гаралтай бүтээгдэхүүнийг шинжилгээнд хамруулж иргэдийн хүнсний аюулгүй байдлыг хангаж ажиллана.

3.9 Түүхий эдийн бэлтгэн нийлүүлэх нэгдсэн цэгийг бий болгож эрүүл аюулгүй орчин бий болгоно.

3.10 Хурдан морь сонирхогч, уяачдын санаачилгыг дэмжиж ажиллана.

3.11 Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс шир, ноос ноолуур түүхий эд бэлтгэн тушаасан малчин мал бүхий иргэдэд мөнгөн урамшуулал олгох тогтолцоог улам сайжруулна.

3.12 Атрын 4-р аяныг орон нутагтаа хэрэгжүүлэн ажиллана.

3.13 Төмс хүнсний ногоо тариалагчдыг дэмжин Орон нутагт тариалсан төмс хүнсний ногоогоор сумын иргэдээ бүрэн хангах бодлогыг хэрэгжүүлнэ.

3.14 Хүлэмжийн АА-г бодлогоор дэмжин 3-н улирлын нарлаг хүлэмжийн технологийг нэвтрүүлнэ.

3.15 Зоорийн АА-г дэмжин 50 тн-оос дээш багтаамжтай зоорь шинээр барьсан иргэд АА-н нэгжийг урамшуулна.

ДӨРӨВ:НОГООН ХӨГЖИЛ- ЭКО ХОТ

4.1 ЧИНГИС хотод “НОГООН ХӨГЖИЛ-ЭКО ХОТ” төслийг хэрэгжүүлнэ.

4.2 Чингис хотын ногоон байгууламжийн төлөвлөгөөний дагуу Баатруудын гудамж, Навааннэрэнгийн гудамж, Пунцагийн гудамж, Өндөрхааны гудамж, Тээвэрчдийн гудамж, Тариаланчдын гудамж, Ардчилсан үндсэн хуулийн гудамж, Мянганы зам дагуу ногоон байгууламжуудыг шинээр бий болгоно.

Иргэд, ААН-үүдийн мод, цэцэг тарих, ногоон байгууламж байгуулах төсөл хөтөлбөрийг дэмжинэ.

4-р баг 19, А-18 байрны хойно цэцэрлэгт хүрээлэн шинээр байгуулна.

5-р баг Т-173 байрны баруун талд цэцэрлэгт хүрээлэн шинээр байгуулна.


4-р баг Өндөрхаан хорооллын дундах талбайд цэцэрлэгт хүрээлэн шинээр байгуулна.

4-р баг Холбооны 8 айл болон эмнэлгийн 8 айлын дунд цэцэрлэгт хүрээлэн шинээр байгуулна.



ТАВ: ДЭД БҮТЭЦ

- 5.1 Хэрлэн сумын 6-р баг малчдын хороо руу засмал зам тавина.
- 5.2 Ундны усны худгийг шинээр ухаалаг худаг болгоно.
- 5.3 Шинэ суурьшлын бүсүүд рүү цахилгаан эрчим хүч тавина.
- 5.4 Багийн төвийн гадна тохижилтыг хийж дуусгана.
- 5.5 Бүх гэр хорооллыг инженерийн шугам сүлжээнд холбоно.
- 5.6 Чингис хотын төвийн засмал замыг бүрэн шинэчлэн дуусгана.
- 5.7 Гэр хорооллын болон орон сууцуудын дунд стандартад нийцсэн тоглоомын талбайг байгуулна.
- 5.8 Гэр хорооллын хонхор хотгорыг тэгшилж янзална.
- 5.9 Чингис хотын нийтийн эзэмшлийн талбайд түүх соёлын онцлогт тохирсон хөшөө дурсгалыг бий болгоно.
- 5.10 Хотын бүх нутаг дэвсгэрийг камержуулах ажлыг дэс дараатай хийж гүйцэтгэнэ.
- 5.11 Нийтийн тээврийн тоог нэмэгдүүлж ,автобусны буудлыг нэмэгдүүлнэ.
- 5.12 4-р багийн Цацал хорооллын баруун,зүүн талд засмал зам тавина.
- 5.13 Орон сууцуудын дээврийн засварын ажлыг үргэлжлүүлнэ.
- 5.14 Хэрлэн гол руу амралтын гудамж нэмж тохижуулна.
- 5.15 Тахилгат тосгонд үүрэн телефоны сүлжээ оруулна.
- 5.16 5-р багт ахуйн үйлчилгээний төв шинээр бий болгоно.
- 5.17 Дулааны станц барьж байгуулна.
- 5.18 Чингис хотын их тойргийн авто замын сүлжээг бий болгоно.
- 5.19 Өлзийт тосгонд -Улаанбаатар-Хэнтий чиглэлийн авто замтай холбох /12 км орчим/
- 5.20 Өлзийт тосгонд соёлын төвийн барилга шинээр барилга барих/ ашиглах боломжгүй/
- 5.21 Өлзийт тосгонд Спорт заал шинээр барих/зориулалтын спорт заалгүй /
- 5.22 Өлзийт тосгоны Сургуулийн дотуур байранд их засвар хийх
- 5.23 Өлзийт тосгоны төвд нэгдсэн халаалтын зуух барьж төсвийн байгууллагуудыг холбох/утааг бууруулах/
- 5.24 Өлзийт тосгоны цахилгаан дамжуулах агаарын шугамыг иж бүрэн шинэчлэх /ухаалаг сүлжээг нэвтрүүлэх/
- 5.25 Өлзийт тосгоны эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмжийг шинэчлэх



- 5.26 Өлзийт тосгонд ухаалаг худаг шинээр бий болгоно.
- 5.27 Тахилгат тосгонд Захирагчийн ажлын албаны барилга шинээр барих
- 5.28 Тахилгат тосгоныг Халаалтын нэгдсэн шугамтай болох
- 5.29 Бэлчээрийн худаг гаргах
- 5.30 Тахилгат тосгоны хуучин захирагчийн ажлын албаны барилгыг их засварт оруулж соёлын төв болгох
- 5.31 Тахилгат тосгоны Төрийн албан хаагчдын орон сууцнуудад их засвар хийх
- 5.32 Тахилгат тосгоны Цэцэрлэгийн барилгад шинээр их засвар хийх
- 5.33 Тахилгат тосгоныг шилэн кабелд холбох
- 5.34 Тахилгат тосгонд шинээр спорт заал барих
- 5.35 Малчдын худгийг нэмэгдүүлнэ.
- 5.36 Мал угаалгын ванн шинээр барих /БАХ, Аравтын бүлгүүдийн дунд тус бүр нэг/

ЗУРГАА : БОЛОВСРОЛ

- 6.1. Хүн амын төвлөрөл ихтэй газруудад нэмж цэцэрлэг барина.
- 6.2 СӨБ-ын багш нарын тасралтгүй хөгжлийг дэмжих зорилгоор мэргэжил арга зүйн сургалтуудад дэмжлэг үзүүлнэ.
- 6.3 СӨБ-ын багш ажилтнуудын туршлага судлах үйл ажиллагааг дэмжинэ.
- 6.4 Сумын яслийн үйлчилгээ хамрах хүрээг нэмэгдүүлж, шинээр ясли барина.
- 6.5 ЕБС-ийн багш нарын мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих зорилгоор мэргэжил арга зүйн сургалтуудыг БСУГ, сургуулиудтай хамтран зохион байгуулна.
- 6.6 Тусгай хэрэгцээт \хөгжлийн бэрхшээлтэй\ хүүхэд ердийн сургуульд сурах, хөгжих орчин нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарна.
- 6.7 ЕБС-ийн өдөр өнжүүлэх анги, бүлэг хичээллүүлэхийг дэмжинэ.
- 6.8 Сурагчдын авьяас сонирхол, мэдлэг чадварыг хөгжүүлэх зорилготой сонгон, секц, дугуйланг дэмжиж ажиллана.
- 6.9 Улс, бүсийн чанартай олимпиад уралдаан тэмцээнд амжилттай оролцсон багш, суралцагчийг алдаршуулж, дэмжиж урамшуулна.
- 6.10 Ном унших үйлийг дэмжиж, номын сан өргөөг олон нийтэд хүртээмжтэй байгуулах, түүгээр үйлчлүүлэх санал санаачилгыг дэмжиж, ном унших хөдөлгөөнийг өргөжүүлнэ.



- 6.11 Сургууль цэцэрлэгийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, эко таатай орчин бүрдүүлэхэд хамтарч ажиллана.
- 6.12 Сургуулиудын гадна тохижилт, биеийн тамирын талбайг стандарт хангасан, хүүхдэд ээлтэй, аюулгүй, таатай орчин бүрдүүлэхэд анхаарч ажиллана.
- 6.13 Сумын иргэдийн мэргэжлийн боловсрол эзэмших идэвх санаачилгыг дэмжинэ.
- 6.14 Уламжлал болон зохиогддог Чингис хотын нэрэмжит массын олимпиадын цар хүрээ чанарыг улам сайжруулан, амжилттай оролцсон сургууль, анги хамт олон, багшийг урамшуулж алдаршуулна.
- 6.15 Монгол бичиг төрийн бичиг болохтой холбогдуулан иргэдийн үндэсний бичгээ сурах санал санаачилгыг дэмжиж ажиллана.
- 6.16 УИХ, аймгийн засаг даргын мөрийн хөтөлбөрт заасан боловсролын салбарт хамаарах заалтуудыг хэрэгжүүлж ажиллана.

ДОЛОО:ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА

- 7.1 Аймгийн хурлын шийдвэрээр албан бусаар нэрлэгдсэн Өндөрхаан хот-Чингис хотын нэршлийг УИХ,Засгийн газрын төвшинд тавьж эцэслэн шийдвэрлүүлнэ.
- 7.2 Сонгуулийн үр дүнд томилогдсон, сонгогдсон албан тушаалтнуудтай батламж гэрээ байгуулж хариуцлага тооцож ажиллана.
- 7.3 Төрийн албан хаагчдыг чадваржуулж, хүнд сурталгүй төрийн үйлчилгээ нэвтрүүлэн төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.
- 7.4 Орон нутгийн хөгжлийн сан, жижиг дунд бизнесийг дэмжих сангийн үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй болгож,иргэдийн хяналтын тогтолцоонд шилжүүлнэ.
- 7.5 Төрийн албан хаагчийн ажлын үр дүнг үнэлэхдээ, ажлын гүйцэтгэл, ёс зүй, сахилга бат хариуцлагыг шалгуур болгож,зөрчил гаргасан төрийн алба хаагчид хариуцлага тооцож ажиллана.
- 7.6 Чингис хотын төв гудамж талбайг камержуулан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж таслан зогсоох ажлыг эрчимжүүлнэ.
- 7.7 Төрийн шат шатны байгууллагад архи согтууруулах ундаа хэрэглэх байдлыг таслан зогсоож архигүй орчин бүрдүүлнэ.
- 7.8 Төрийн байгууллагын үйлчилгээнд цахим технологи нэвтрүүлж, иргэд төрийн үйлчилгээг шуурхай авдаг болгоно.

